

“ЭРДЭНЭТ СУВРАГА” ХК

**CPTA  
AUDIT LLC**  
**“СИ ПИ ТИ ЭЙ АУДИТ”ХХК**

БАТАЛГАЛЖУУЛАЛТ, АУДИТ, НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, ЗӨВЛӨГӨӨ

Баянзүрх дүүрэг, 3-р хороо, Оршил төв 501 тоот  
Улаанбаатар хот, Монгол улс, 16010, Утас: 11-976-99046494

Огноо: 2023-02-20

№23/

Улаанбаатар хот

**ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН**

**“ЭРДЭНЭТСУВРАГА” ХК-ийн хувьцаа эзэмшигчдээ**

**Дүгнэлт**

Бид 2022 оны 12 сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцэээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, монгол гүйлгээний тайлан болон ач холбогдуулж өндөртэй нягтлан бодох бүртгэлийн хураангуйг багтаасан санхүүгийн тайлантгийн тэмдэглэлээс бүрдсэн “ЭРДЭНЭТ СУВРАГА” ХК компанийн санхүүгийн тайландауд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлантгуд нь бүхий л материаллаг асуудлаар “ЭРДЭНЭТ СУВРАГА” ХК компанийн 2022 оны 12 сарын 31-ээрх санхүүгийн байдал, тухайн жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайллагналын Олон Улсын Стандартуудын дагуу үнэн зөв толилуулж (эсвэл эдгээрийн талаар үнэн бөгөөд зөв ойлгоц өгч) байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлантгийнхаа Санхүүгийн Тайлантгийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага гэсэн хэсэгт харуулав. Бид санхүүгийн тайлантгийн энэхүү аудитын ажилд хамаарах ёс зүйн шаардлагуудын дагуу компаниас хараат бус ба эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, тохиromжтой гэж итгэж байна.

**Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн Тайланд хүлээх  
Үүрэг Хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайллагналын олон улсын стандартуудын дагуу эдгээр санхүүгийн тайлантг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайллагналгүй санхүүгийн тайлантгудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

## “ЭРДЭНЭТ СУВРАГА” ХК

### 2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага Компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэсээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ. Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

#### Санхүүгийн тайлангийн Аудитад хүлээх Аудиторын хариуцлага

Хийж гүйцэтгэсэн аудит дээрээ үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт гаргах нь бидний хариуцлага юм. Бид аудитаа Аудитын олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Тэдгээр стандартууд нь ёс зүйн шаардлагад нийцэж ажиллах мөн санхүүгийн тайлангууд нь материалын алдаагүй эсэх талаар зохимжтой баталгаажуулалтыг олж авахын тулд аудитаа төлөвлөж гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн дүн болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуудыг гүйцэтгэх ажил багтана. Сонгон авах горимууд нь залилан болон алдааны улмаас санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдсэнээс үүсэх эрсдлийн үнэлгээ зэргийг багтаасан аудиторуудын мэргэжлийн үнэлэмжкээс хамаарна. Тэдгээр эрсдлийн үнэлгээнүүдийг хийхдээ аудитор нь байгууллагын дотоод хяналтын үр нөлөөтэй эсэх талаар дүгнэлт гаргах зорилгоор биш зөвхөн тухайн нөхцөл байдалд зохистой аудитын горимуудыг зохиох үүднээс байгууллагын санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, тэдгээрийг үнэн зөв толилуулах үйл явцад холбоотой дотоод хяналтыг харгалзаж үздэг.

Мөн аудитын ажилд хэрэгжүүлж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын таарамж, удирдлагын хийсэн нягтлан бодох бүртгэлтэй холбоотой тооцооллуудын бодитой эсэхийг үнэлж үзэх ажил орно.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

#### Хэрэглээний хязгаарлалт

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 94 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох Компанийн хувьцаа эзэмшигчдийн захиалсан аудиттай холбогдуулан Компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулж гаргасан болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын омно хариуцлага хүлээхгүй болно.

#### СИ ПИ ТИ ЭЙ АУДИТ ХХК

Мэргэшсэн нягтлан бодогч

Гүйцэтгэх захирал



Ч.ЭНХЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот  
Баянзүрх дүүрэг, 3-р хороо, Оршил төв 501 тоот

Утас: 976 – 9904 6494; 86030388